



МОНГОЛ УЛСЫН
ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА,
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД

Засгийн газрын XII байр, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 11-310612, Факс: 11-322904
Цахим шуудан: info@mudch.gov.mn
Цахим хуудас: www.mcud.gov.mn

2026.06.08 № 01/2043

танай 2026.05.29-ны № 31 -т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.БААТАРХҮҮ ТАНАА

Асуулгын тухай

Таны 2026 оны 31 дугаартай албан бичгээр ирүүлсэн Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн тухай асуулгуудтай танилцлаа.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар газрын харилцааны асуудал нь Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд, Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлд зааснаар газрын талаарх хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, улсын хэмжээнд газар зохион байгуулалтын үйл ажиллагааг эрхлэх, газрын кадастрын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх, улсын газрын мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх зэрэг асуудал нь газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх хэмжээнд тус тус хамаарч байна.

Иймд Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3.3 дахь газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх хэмжээнд “газрын кадастр эрхлэх, аймаг, нийслэлийн газрын мэдээллийн сан байгуулж, олон нийтэд мэдээллээр үйлчлэх” гэж заасны дагуу Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт хандаж холбогдох асуулгаа хүргүүлэхийг хүсье.



Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
Яамны удирдлага
Сайд
Энхтайван Бат-Амгалан
2026-06-08 10:39:04